

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 4 (4)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Хятадын нүүрсний хэрэглээ 4,8 тэрбум тоннд хүрнэ. 2020 онд БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 4,8 тэрбум тн-д хүрнэ гэж тус улсын нүүрсний ассоциациас таамаглал дэвшүүлжээ. Хятадын эрчим хүчний хэрэглээний 60%-ийг нүүрс эзэлдэг.
- Алт олборлолт төлөвлөсөнөөс давжээ. 2013 оны эхний 10 сарын байдлаар зэсийн үйлдвэрлэл 622,3 мянган тонн буюу 79 хувийн гүйцэтгэлтэй, нүүрсний үйлдвэрлэл 21,9 сая тонн буюу 75,7 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол алт олборлолт төлөвлөсөн хэмжээнээсээ давж, 7746 кг-ийг олборлосноор 193,7 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Монгол Оросын засгийн газрын комиссын ээлжит хуралдаан энэ долоо хоногт Москва хотноо хуралдлаа. Хуралдааны үеэр Орос-Хятадыг холбосон төмөр зам, авто зам, газрын тос, байгалийн хийн хоолой болон эрчин хүч дамжуулах шугамыг монгол улс өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан тавихыг санал болгосон талаар ОХУ-ын байгаль орчны ямнаас мэдээлэв.
- Японы Сүмитомо Мицуй Банкинг Корпорейшн-ийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын нээлт өчигдөр боллоо. SMBC өнгөрсөн 8-р сард Монгол банкнаас зөвшөөрөл авсан юм.
- Нефтийн ханш дөрвөн сарынхаа доод түвшинд хүрчээ.
- Еврогийн ханш суларлаа.
- Оросын нүүрсний экспорт нэмэгджээ. 12.6 хувиар өсч 117,83 сая тоннд хүрчээ.
- Монгол улс 10-р сард 2 сая тонн чулуун нүүрс экспортолж, 95,8 сая долларын орлого олсон нь сүүлийн 10 сарын хамгийн өндөр үзүүлэлт юм.
- Хятад төмөр замын хөрөнгө оруулалтаа нэмэгдүүжээ.

Монголын хөрөнгийн зах зээл



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ зээлийн 90 орчим хувийг эзэлдэг, Монголын хамгийн өндөр үнэлгээтэй 20 хувьцаат компанийн хувьцааны үнийг нэгтгэж үзүүлдэг “ТОП 20 Индекс” өнөөдрийн байдлаар 15,702-д хүрч өчигдрийнхөөс 327.49 нэгжээр буюу 2.13 хувиар өссөн байна. Ер нь сүүлийн жил гаруй хугацаанд Топ 20 Индекс 13000–аас 14000–ын хооронд нилээд хэлбэлзлээ. Өөрөөр хэлбэл Монголын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцааны үнэ сүүлийн жил гаруй хугацаанд (дунджаар) өссөн ч үгүй, унасан ч үгүй. Үүнийг доорх зургаас тодорхой харж болно.

Топ 20 Индекс 2008 оноос хойш



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДРУУЛГА



"TURQUOISE HILL RESOURCES" КОМПАНИ ХААЛТТАЙ НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАНА

Turquoise Hill Resources (NYSE: TRQ) компани 1,006,000,000 (нэг тэрбум зургаан сая ширхэг) хувьцааг гаргаж худалдах болсон талаар 11 сарын 26-ны өдөр мэдэгдэл хийлээ.

Оюу Толгой ХК-ийн хувьцаа эзэмшигчид гаргаж буй нэмэлт хувьцааг 11 сарын 25-ны өдрийн NYSE болон TSE хөрөнгийн биржийн хаалтын үнээс 42% (Closing price: 4.25) хямдруулж авах эрхтэй ба энэ нь ойролцоогоор 2.40 америк доллар, 2.50 канад доллар болох юм. Босгосон хөрөнгөө тус компани нь богино хугацаат өр төлбөрөө барагдуулахад ашиглана.

Энэхүү нэмэлт хувьцаа нь хаалттай хүрээнд буюу 2013 оны 12 сарын 6-ны өдрийг хүртэл тус компанийн хувьцааг эзэмшиж буй хувьваа эзэмшигчиддээ санал болгогдоно. Тодруулбал тухайн өдөр тус компанийн хэдэн ширхэг хувьцаа эзэмшиж байгаатай ижил тооны шинэ хувьцааг тус бүрийг нь 2.40 ам доллараар худалдан авах эрхийн үнэт цаас олгогдоно.

Нэмэлт хувьцаа авах эрхээ хэрэгжүүлэх сонирхолтой хувьцаа эзэмшигч нар 2014 оны 1 сарын 7-ны байдлаар нэмэлт хувьцаа авахад шаардлагатай мөнгөө байршуулна. Харин энэхүү эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар шийдсэн хувьцаа эзэмшигч нар эрхээ зарах боломжтой бөгөөд тус эрхийн үнэт цаасны арилжаа энэ оны 12 сарын эхний долоо хоногоос нээгдэнэ. Эрхийн үнэт цаасны арилжаа Нью-Йоркийн Хөрөнгийн биржээр (NYSE: TRQ RT WI) гэсэн кодоор явагдана.

THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT BANK IN MONGOLIA.

МIСС хөрөнгө оруулалтын банкны тухай
МIСС нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа, судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг дотоод гадаадын харилцагчиддаа санал болгодог Монголын ууган хөрөнгө оруулалтын банк юм.

МIСС ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

Эрхлэгч: Э. Оюу.

2013/10/16

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж, MSCI Barra,
OECD.